

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59, 60, 62, 64, 65, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 09:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө хаягт байрлах “Номин юнайтед” төвд биечлэн болон цахим хэлбэрээр хослуулан зохион байгуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах.
 - 2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг батлах.
 - 2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.
3. Компани нь сүүлжийн жилүүдэд бий болсон хуримтлагдсан алдагдлаа нөхөж чадаагүй тул Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2023 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэснийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
4. Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр хурлын зарыг нийтэд эхэлж хүргэхээр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр, 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдрүүдэд өдөр тутмын сонин хэвлэл болон телевиз, радио зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэхээр тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөр тасалбар болгосугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг брокер дилерийн компаниудад 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор дамжуулан тараахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн болон цахим хэлбэрээр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах сүүлчийн хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөр тасалбар болгож, брокер дилерийн компани болон Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20-р хороо, Чингисийн

2024 оны 03 дугаар
сарын 11-ны өдөр

№: 24/07

Улаанбаатар
хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг дүгнэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх хэсэг,
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хурлын
шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг энэхүү тогтоолын хавсралтаар дүгнэсүгэй.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Я.НАВААН

“Улсын их дэлгүүр” ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 03-р сарын 14-ний өдрийн
24/07 дугаартай тогтоолын Хавсралт



КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:
 - a. ОРЛОГО: “Улсын их дэлгүүр” ХК нь 2023 онд үндсэн үйл ажиллагаанаас 7,510,638,000 төгрөгийн түрээсийн орлоготой ажилласан.
 - b. ЗАРДАЛ: “Улсын их дэлгүүр” ХК нь 2024 онд үндсэн үйл ажиллагаандаа 7,172,160,000 төгрөгийн төсөв зарцуулсан.
 - c. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ, АЛДАГДАЛ: “Улсын их дэлгүүр” ХК нь дээрх орлого болон зардалд үндэслэн 2023 онд үндсэн үйл ажиллагаанаасаа 338,478,000 төгрөгийн ашиг олсон байна.
2. ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГАА:
 - a. БУСАД ОРЛОГО: “Улсын их дэлгүүр” ХК нь 2023 онд Нийслэлийн Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 01-р сарын 13-ны өдрийн 001/ХТ2023/00147 дугаартай шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 04-р сарын 21-ний өдрийн 210/МА2023/00845 дугаартай магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн 2023 оны 07-р сарын 04-ний өдрийн шүүх хуралдааны 001/ХТ2023/00147 дугаартай тогтоолын дагуу хариуцагч нараас 800,000,000 төгрөгийн төлбөр хүлээн авсан.
 - b. БУСАД ЗАРДАЛ: “Улсын их дэлгүүр” ХК нь 2023 онд Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11-р сарын 15-ны өдрийн 2022/ШЦТ/889 дугаартай шийдвэр, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 04-р сарын 06-ны өдрийн 2023/ДШМ/381 дугаартай магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчдийн 2023 оны 07-р сарын 06-ны өдрийн хуралдааны 517 дугаартай тогтоолын дагуу бусдад 1,031,901,000 төгрөгийн төлбөр төлсөн.
 - c. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС АШИГ, АЛДАГДАЛ: “Улсын их дэлгүүр” ХК нь дээрх бусад орлого болон бусад зардалд үндэслэн 2023 онд үндсэн бус үйл ажиллагаанаасаа 231,901,000 төгрөгийн алдагдал хүлээсэн байна.
3. ЦЭВЭР АШИГ: “Улсын их дэлгүүр” ХК нь 2023 онд үндсэн үйл ажиллагаанаас 338,478,000 төгрөгийн ашиг олж, үндсэн бус үйл ажиллагаанаасаа 231,901,000 төгрөгийн алдагдал хүлээснээр нийт 106,577,000 төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.
4. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ: 2023 онд 47,572,000 төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн байсан ба бодит гүйцэтгэлээр 106,577,000 төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаар төлөвлөгөөний биелэлт 224% буюу 124%-иар давуулан биелүүлсэн байна.
5. ДҮГНЭЛТ: Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн биелэлтийг хангалттай гэж дүгнэв.

өргөн чөлөө-67/1 тоот хаягт байрлах “Номин юнайтед” цогцолборын 5-р давхарт тус тус хүлээж авахаар тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Я.Навааныг томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Эдийн засагч Ганзоригийн Өсөхбаярыг, тооллогын комиссын гишүүдээр Хуульч Галбадрахын Мягмартуяа, Нягтлан бодогч Нямбаатарын Сүрэнжав нарыг томилсугай.
11. Хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ нарыг томилсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Я.НАВААН